

Аймгийн ИТХ, ИТХТ-ийн тогтоолын хэрэгжилт

Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

2022 оны жилийн эцэс

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
Аймгийн ИТХ-ын тогтоол							
1	1	Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай 2020-11-24 Дугаар 2/04	4. 4. Сумдын Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, орон нутгийн өмчийн газрын дарга нарт ДААЛГАХ нь: 5.1 Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан өөрийн сум, байгууллагатай холбогдол бүхий заалтуудыг хяналтад авч, хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг бүх шатны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусган үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг жилээр тооцон аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байх	Байгууллагын стратеги төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг хугацаанд нь тооцож ажиллаж байна.	100%		
Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол							
2	2	“Монгол хэл бичиг” дэд хөтөлбөр батлах тухай	31. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн	Орон нутгийн дэд хөтөлбөр 5 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 онд 46.7 хувьтай хэрэгжиж байна. Дэд хөтөлбөрөөс 3500100 төгрөгийн санхүүжилт хийсэн.	70%		

		2019-09-23 Дугаар 59	санхүүжилт, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.	Дэд хөтөлбөрийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлаа видео хэлбэрээр бэлтгэн танилцуулж, сурталчлах үйл ажиллагаанд 30 байгууллага идэвх санаачилгатай оролцлоо. ЕБС, СӨБ-ын байгууллагын албан хаагчдаас анхан шат-1074, дунд шат-703, ахисан шат 192 буюу 77 хувь нь монгол бичгийн сургалтад хамрагдаж байна. Мөн 66 байгууллагын 740 албан хаагчид монгол бичгийн хичээлийг заасан байна. Лаборатори 1-р сургуулийн "Эх хэл бичгийн өргөө"-г түшиглэн насан туршийн боловсрол төвтэй хамтран иргэдэд монгол бичгийн хичээлийг заахаар төлөвлөж байна. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хүрээнд Монгол бичгийн хичээлийг /МУГБ Б.Даваадорж/ Ховд ТВ бэлтгэн цахимаар хүргэж байна. Тус хичээлийг Үндэсний бичиг, өв соёл-Олон ястны бахархал цахим хуудсаар түгээсэн. Монгол бичгийн гайхамшиг, сурч судлахын учир, ач холбогдлыг таниулах "Өвлөн дээдлэх үндэсний бичиг минь" лекцийг хэлний бодлогын салбар зөвлөлийн гишүүн Б.Бадамцэцэг соёл, урлагийн салбарын удирдах ажилтнууд, аймгийн төвийн 7 байгууллагын нийт 300 гаруй албан хаагчдад уншиж, үндэсний бичгээ сурахыг уриаллаа. ЕБС, СӨБ-ын байгууллагаас гэрэлтдэг том хаяг-14, жижиг хаяг-56, орчин бүрдүүлсэн 42, дотор хаягжилт буюу 940 анги танхимын хаягийг монгол бичгээр бичсэн. Жаргалант сумын 13 байгууллага том жижиг хаягтай болсон байна. Хавсралт : 1 файл			
3	3	Орон тооны бус зөвлөл байгуулах	29. Аймгийн хэлний бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 17 дугаар тогтоолоор Аймгийн "Хэлний бодлогын салбар зөвлөл" 19 хүний	70%		

		<p>тухай 2021-03-04 Дугаар 17</p>	<p>баталж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар ханган, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг дарга, салбар зөвлөлийн дарга /Б.Дүгэржав/-д даалгасугай.</p>	<p>бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. “Үндэсний бичиг үсгээ сурах, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх тухай”, “Үндэсний бичиг үсгээ сурах, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай, хамтран ажиллах тухай” албан бичгийг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, захирал, эрхлэгч, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж хэрэгжилтэд удирдлагаар ханган ажиллаж байна. Мөн 17 сумын хэлний бодлогын салбар зөвлөл байгуулагдан, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Сумын хэлний бодлогын салбар зөвлөлийн гишүүдийн дунд групп нээн харилцан туршлагаа хуваалцахаас гадна мэдээллээ шуурхай дамжуулан ажиллаж байна. Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс Ховд аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг судалж, Ховд аймгийн биет бус өв тээгчидтэй уулзаж, аман аялгуу, аман уламжлалыг баримтжуулахаар 2 удаа 5 өдөр хамтран ажилласан. /ХБҮЗ-ийн дарга С.Дулам, ХБҮЗ-ийн ажлын албаны ажилтан Ц.Даваасүрэн/ Монгол хэлний хуулийн хэрэгжилтийг хянан, төрийн байгууллагын болон аж ахуйн нэгж 82 байгууллагын хаягжилтыг үзлээ. Төрийн байгууллагын архив, албан хэрэг, хөтлөлт хариуцсан ажилтнуудад "Үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах арга зүй" сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 16 сумын ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан, аймгийн ЗДТГ-ын хүрээний 44 байгууллагын 44, нийт 60 хүн хамрагдахаас 46 нь хамрагдсан байна. Мөн Хөгжил политехник коллежийн 30 багш ажилтанд уг сургалтыг зохион байгууллаа. Төрийн албаны шалгалтад орж буй иргэдэд монгол хэл, бичгийн сургалтыг аймгийн төрийн албаны зөвлөлтэй хамтран 2 удаа зохион байгуулсан.</p>			
--	--	---	--	---	--	--	--

4	4 “Тогтвортой хөгжлийн боловсрол” дэд хөтөлбөр батлах тухай 2021-09-23 Дугаар 60	32. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.	Орон нутгийн дэд хөтөлбөр 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ зохион байгуулсан. Хэрэгжилтийн дундаж биелэлт 63%-тай. Энэ жил дэд хөтөлбөрөөс 6936000 төгрөгийн санхүүжилт авсан .Тогтвортой хөгжлийн төлөөх ЕБС-ын хамтын ажиллагаа- санаачилга, "ТХБ-Орон нутгийн дэд хөтөлбөрийн"- ийн хэрэгжилт туршлага солилцох, харилцан суралцах өдөрлөгт 8 сургууль 16 цэцэрлэгийн удирдлага багш сурагч эцэг эх болон төслийн 4 сургууль БШУГ, ТЗЗОНБ, төслийн хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөл нийт 101 хүн хамрагдан нийт 22 байгууллагад үйл ажиллагаа түгээв. Буянт, Мөнххайрхан 1,2 дугаар сургуулиуд үйл ажиллагаагаа “Ховд-Тогтвортой хөгжлийн боловсрол” цахим хуудсаар түгээж байна. Гишүүдийн тоо 740 хүч өмнөх жилээс 500 гаруй гишүүдээр нэмэгдсэн байна . “Хоггүй -Ногоон Ховд”- аянг 25 сургууль 33 цэцэрлэгийн дунд зохион явуулаа. Тус аянд 24 сургууль 33 цэцэрлэг оролцсоноос 5 шалгуурын дагуу үнэлж дүгнэв. Сургуулиас Прогресс,Манхан ,Дөргөн, цэцэрлэг Жаргалант1,16,15,2,3 дугаар цэцэрлэгүүд манлайлан оролцсон байна. Хавсралт : 1 файл	70%		
5	5 Чадварлаг багш, оюутан, сурагч” дэд хөтөлбөр батлах тухай 2021-09-23 Дугаар 61	32. Хөтөлбөр болон журмуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж хэрэгжилтийг ханган, үр дүнг	Орон нутгийн дэд хөтөлбөрийн хүрээнд багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх, нэр хүндийг өсгөх зорилгоор “Чадварлаг багш” шалгаруулах болзол гаргаж шагнаж урамшуулж байна. 2021 онд 5 багшийг 13.8 сая, 2022 онд мөн 5 багшийг 21 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. 2022 онд элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн 13 суралцагчийг 6,9 сая төгрөгөөр, аймагтаа тэргүүлсэн 3 сургуулийг 8.76 сая төгрөгөөр, улсын хэмжээнд амжилт гаргасан	70%		

			тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.	мэргэжилтэн, багш нарыг 2.8 сая төгрөгөөр шагнаж нийт дүнгээрээ 39.46 сая төгрөгийн санхүүжилт олголоо. 2021 онд Аймгийн засаг даргын нэрэмжит “Чадварлаг мэргэжилтэн-Шинэ Ховдын ирээдүй” тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргасан 15 оюутны материалыг хэлэлцээд журмын шаардлага хангасан 10 оюутанд дэмжлэг урамшууллыг олгосон. Ховдын ирээдүй” аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох журам хэрэгжүүлж 2021 онд 13 оюутанд 13 сая төгрөг, 2022 онд журмын шалгаруулалтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан зарлаад байна.			
6	6	“Хариуцлагатай тунгалаг төр” аймгийн дэд хөтөлбөр батлах тухай 2021-12-22 Дугаар 161	2. 3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхи санаачилгатай ажиллаж, хөтөлбөрийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.	Хариуцлагатай тунгалаг төр дэд хөтөлбөрийн хүрээнд боловсрол, шинжлэх ухааны газар идэвхи санаачилгатай ажиллаж, хөтөлбөрийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг ханган ажиллаж 2022 оны жилийн байдлаар манай байгууллагад ёс зүйн болон эрх зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагч байхгүй байна. Байгууллагын санхүү төсөл, үйл ажиллагааны нээлттэй байдлыг ханган ажиллаж төсөв санхүүгийн мэдээллийг шилэн дансны хуулийн дагуу нийтэд ил тод мэдээллэн ажиллаж байна. Мөн салбарын нэгдсэн хурал зөвлөгөөн цагтаа эхлэж цагтаа дуусах соёлыг хэвшүүлээд байна.Салбарын хэмжээнд сургалт үйл ажиллагаа цахим болон танхимаар цагтаа эхэлж хэвшсэн. 7 хоногийн Лхагва гаригийн 9 цагт сургууль цэцэрлэгтэй цахим шуурхай уулзалт тогтмол явагддаг. Байгууллагын нэгдсэн хурал Даваа гарагт 8:30 минутад тогтмол хийгдэж хэвшсэн. 2022 оны байдлаар нийт 400 албан бичиг ирж, 382 албан бичиг явуулсан байна. Даргын тушаал 93 гарсанаас А тушаал 75, Б тушаал-18 гарсан байна. Байгууллагад нийт 80 өргөдөл ирснээс гэрчилгээ нөхөн авах-7 тэтгэмж хүсэх-19, байгууллагын	100%		

				ажилтан чөлөө хүссэн-9, салбарын байгууллагын ажилтан чөлөө хүссэн-9, гомдол гаргасан-12, ажил хүссэн-8, санал хүсэлт-13, өргөдөл гаргах-3 байна. Ховд аймгийн багшийн ёс зүйн зөвлөлийг Аймгийн засаг даргын 2021 оны 10 сарын 19-ны өдрийн А/596 тоот тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Ёс зүйн зөвлөл нийтдээ 5 удаа хуралдаж 10 өргөдөл гомдлыг шийдвэрлээд байна. Ёс зүйн жилийн хүрээнд сургууль цэцэрлэгийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг цахим сургалтад хамруулж ёс зүйн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллалаа. Зөвлөлийн гишүүн Д.Батнасан Жаргалант сумын 5, 13 дугаар цэцэрлэг, Булган сумын Минжит Булган, Жаргалант сумын 2, 6-р сургуульд ёс зүйн сургалтыг танхимаар зохион байгуулж аймгийн нийт ёс зүйн зөвлөлийн гишүүд 136 хүнийг хамруулан онлайн сургалтыг 1 удаа зохион байгууллаа.			
7	7	“Чанартай боловсрол” дэд хөтөлбөр батлах тухай 2021-12-30 Дугаар 178	1. 3.Хөтөлбөр, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.	Чанартай боловсрол” дэд хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүллээ. БҮТ өөс бүх сургуульд гүйцэтгэлийн үнэлгээг хэрэгжүүлсэн бол хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж аймгийн 9 дүгээр ангийн математикийн хичээлээр 46 бүлгийн 1388 сурагч буюу нийт хүүхдийн 91,9% , 9 дүгээр ангийн монгол хэлний хичээлээр 57 бүлгийн 1496 буюу 95,2%, 5 дугаар ангийн монгол хэл 68 бүлгийн 1956 буюу 95,8%, 5 дугаар ангийн биеийн тамир эрүүл мэндийн 68 бүлгийн 2014 буюу 95,4%, СӨББ-ын ахлах бүлгийн танин мэдэхүйн хөгжлийн түвшний хөгжилөөр шалгалт авсан бөгөөд нийт чанарын үнэлгээний дундаж 53%-тай шалгагдсан нь БҮТ-өөс шалгагдсан үнэлгээтэй ихээхэн дөхөж байна Иймд чанарын үнэлгээний тогтолцоог улам сайжруулж сургалтын чанарыг сайжруулахаар ажиллаж байна. Аймгийн шалгалт нь орон нутгийн өөрөө удирдах	100%		

				байгууллага болон эцэг эхийн хяналт дор зохион байгуулагддаг.			
--	--	--	--	---	--	--	--